



САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/076/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Цэцэгмаа Утас: 99488754 Цахим хаяг: tsetsegnaab@audit.gov.mn Аудитор: С.Санчирмаа Утас: 99282488 Цахим хаяг: sanchirmaas@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2025/076/НА-СТА-ТШЗ



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 02. 21 № 32

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 159 дүгээр тогтоолоор ахмад настанд хөнгөлөлттэй үнээр үйлчилгээ үзүүлэх амралт, сувиллын газрын нийгмийн халамжийн сангаас олгох 1 ор хоногийн хөнгөлөлтийн хэмжээг 15.0 мянган төгрөгөөс 35.0 төгрөг болж шинэчлэн тогтоосон.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас 99,801.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж шилжүүлэн авсан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан салбарын тоног төхөөрөмж худалдан авах төлөвлөгөөнд тусгасны дагуу Ахмадын сувилалд шаардлагатай тоног төхөөрөмжийн 9.5 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил төсвийн хөрөнгөөр худалдан авсан.

8225020087

Аудитын гол асуудал

Улсын төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 670,509.4 мянган төгрөгөөр өссөн нь төрийн албан хаагчдын цалин, хөлс нэмэгдсэн, төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгосонтой холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус байгууллагын төсөв захирагч 14 зорилт, 73 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, аймгийн Засаг даргаас биелэлтийг 89.5 хүргүүлсэн боловч үнэлээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ГҮНЖИДМАА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	25,772.1	37,088.7
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	736,090.6	784,463.1
Нийт хөрөнгийн дүн	761,862.7	821,551.8
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	761,862.7	821,551.8
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	761,862.7	821,551.8
Үйл ажиллагааны орлогын дүн	1,315,737.2	2,134,215.8
Үйл ажиллагааны зардлын дүн	1,381,629.3	2,074,526.7
Үйл ажиллагааны үр дүн	(65,892.2)	59,689.1
Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
Үйл ажиллагааны нийт үр дүн	(65,892.2)	59,689.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	761,862.7	761,862.7
Тайлант оны үр дүн	-	59,689.1
Эцсийн үлдэгдэл	761,862.7	821,551.8
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,310,141.0	2,013,199.8
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,430.0	15,835.0
Үйл ажиллагааны ЦМГ	1,430.0	15,835.0
Хөрөнгө оруулалтын ЦМГ	1,430.0	15,835.0
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,915,415.3	1,869,597.8
Урсгал зардал	1,915,415.3	1,869,597.8
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,915,415.3	1,936,685.3
Улсын төсвөөс санхүүжих	1,834,015.3	1,834,015.3
Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 12.3 сая төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Дэлхийн зөн Олон улсын байгууллагаас ирсэн 11.6 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна. нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.
- Нэмэлт санхүүжилтийн дансны хэлбэлзэл хичээл үйлдвэрлэлийн дадлага зардал 0.6 сая төгрөгийн зөрүүтэй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 15.8 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 15.8 сая төгрөгийн 1 зөрчил² илэрсэнд 1 зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5.2 Албан шаардлага

1. Төсвийн хөрөнгөөр 15.8 сая төгрөгийг машин тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цахим дэлгүүрт байршсан тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс худалдах авахгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Говь-Алтай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	2	12.3	1	11.6	1	0.6	2	12.3	-	-	-	-
Дүн	2	12.3	1	11.6	1	0.6	2	12.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		ХХБ-д шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Говь-Алтай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	1	15.8	-	-	1	15.8	-	-	-	-	-	-
Дүн	1	15.8	-	-	1	15.8	-	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			